

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



“МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ” ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2023/21/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Орхон аймаг 2023 он	Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 7035 9826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 7035 8505 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn Аудитор: А.Лхагвагэрэл Утас: 99360333 Цахим хаяг: mnbaudithk@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.02.24 № 58

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
М.ОТГОНБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг, хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Улсын төсвөөс 428,678.7 мянган төгрөгийн санхүүжилт авч төсвийн нийт зарлагыг 98.9%-тай зарцуулан, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант хугацааны эцэст Улсын бүртгэлийн ерөнхий газраас 21 аймгийн салбаруудын албан бичиг хадгалах сейфийг шинэчлэх зорилгоор 19,844.0 мянган төгрөгийн 16 ширхэг сейфийг ерөнхий гэрээний нөхцөлөөр худалдан авахаар тус байгууллагын багаж техник хэрэгслийн зардлаас 2022 оны 12 дугаар сарын 25-нд шилжүүлсэн байна. Сейф тус байгууллагад бодитоор ирээгүйн улмаас шилжүүлсэн төлбөрийн дүнгээр авлагаар бүртгэхээс өөр боломжгүй болсон байна.

Энэ нь дээд шатны төсвийн захирагчаас оны эцэст хэрэгжих боломжгүй хугацаанд шийдвэр гарган санхүүжилтийг шилжүүлэхийг шаардсан нь зүй бус авлага үүсэх нөхцөл бүрдүүлж байгааг анхаарах шаардлагатай байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>60,289,064.10</u>	<u>67,941,869.87</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	843,305.50	2,452,753.00
31213	Арилжааны банк дахь харилцах	843,305.50	2,452,753.00
33	АВЛАГА	00.00	19,844,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	19,844,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	59,445,758.60	45,645,116.87
351	Түүхий эд материал	15,007,012.10	10,765,162.00
35110	Тусгай зориулалттай материал	15,007,012.10	10,765,162.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,002,725.00	3,391,490.00
354	Хангамжийн материал	43,436,021.50	31,488,464.87
35410	Бичиг хэргийн материал	1,946,545.00	1,351,246.50
35420	Аж ахуйн материал	8,298,000.00	1,798,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,925,349.00	3,012,349.00
35440	Түлш, шатах тослох материал	1,319,985.00	236,301.87
35470	Бусад хангамжийн материал	26,946,142.50	25,090,567.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>81,337,102.42</u>	<u>106,227,285.82</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	81,337,102.42	106,227,285.82
392	Биет хөрөнгө	81,337,102.42	106,227,285.82
39203	Авто-тээврийн хэрэгсэл	58,000,000.00	58,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-58,000,000.00	-58,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	198,913,569.31	184,568,568.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	-
		132,559,532.19	-89,731,135.73
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,514,870.00	52,514,870.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-37,531,804.70	-41,125,016.74
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>141,626,166.52</u>	<u>174,169,155.69</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>843,305.50</u>	<u>2,452,753.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	843,305.50	2,452,753.00
414	Урьдчилж орсон орлого	843,305.50	2,452,753.00
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	843,305.50	2,452,753.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>140,782,861.02</u>	<u>171,716,402.69</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	140,782,861.02	171,716,402.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	148,156,954.32	148,156,954.32
51101	Өмч: - төрийн	148,156,954.32	148,156,954.32
512	Хуримтлагдсан үр дүн	-7,374,093.30	23,559,448.37
51210	Өмнөх үеийн үр дүн	-7,374,093.30	-7,374,093.30
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	30,933,541.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>141,626,166.52</u>	<u>174,169,155.69</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	260,170,090.00	538,404,997.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,989,290.00	62,176,297.41
120	Нийтлэг татварын бус орлого	11,989,290.00	62,176,297.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,887,210.00	6,500,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,887,210.00	6,500,000.00
120009	Бусад орлого	102,080.00	104,312.87
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		41,298,151.54
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		14,273,833.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	248,180,800.00	476,228,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	190,614,300.00	428,678,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	190,614,300.00	428,678,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	57,566,500.00	47,550,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,600,000.00	47,550,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,966,500.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	261,207,402.28	500,971,455.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	261,207,402.28	500,971,455.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	261,207,402.28	492,862,160.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	154,989,437.04	331,498,452.00
210101	Үндсэн цалин	111,499,640.68	240,344,574.78
210102	Нэмэгдэл	31,248,039.00	58,798,030.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,152,600.00	5,857,500.00
210104	Урамшуулал	00.00	7,654,118.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,089,157.36	18,844,229.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,835,236.00	41,757,101.00
210201	Тэтгэврийн даатгал	15,719,501.12	28,963,277.83
210202	Тэтгэмжийн даатгал	1,599,689.47	3,381,025.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,205,831.37	2,583,860.37
210204	Ажилгүйдлийн даатгал	300,929.10	620,812.33
210205	Эрүүл мэндийн даатгал	3,009,284.94	6,208,125.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,196,180.00	34,526,145.00
210301	Гэрэл, цахилгаан	2,634,187.00	4,049,605.00
210302	Түлш, халаалт	1,839,555.00	2,235,334.00
210303	Цэвэр, бохир ус	2,326,340.00	2,551,606.00
210304	Байрны түрээс	10,396,098.00	25,689,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,354,565.50	21,006,466.50
210401	Бичиг хэрэг	2,122,816.50	12,047,498.50
210402	Тээвэр, шатахуун	748,200.00	2,287,996.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	291,199.00	893,547.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	192,350.00	2,835,850.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	2,941,575.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	143,000.00	2,874,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	143,000.00	1,401,000.00

210604	Урсгал засвар	00.00	1,473,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,116,080.20	38,146,528.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,043,600.00	21,280,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,480.00	59,480.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,013,000.20	16,276,538.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,572,903.54	23,052,968.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,911,720.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	145,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,661,183.54	22,907,968.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	8,109,295.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,743,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,743,600.00
213	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	6,365,695.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,451,077.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,914,618.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-1,037,312.28	37,433,541.67
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	6,500,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	6,500,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-6,500,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-1,037,312.28	30,933,541.67

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	680,956,990.38	845,607,166.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	325,927,190.38	369,378,466.50
120	Нийтлэг татварын бус орлого	325,927,190.38	369,378,466.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	325,927,190.38	369,378,466.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	314,559,247.38	369,378,466.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,367,943.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	355,029,800.00	476,228,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	291,163,300.00	428,678,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	291,163,300.00	428,678,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	63,866,500.00	47,550,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,900,000.00	47,550,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44966500.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	648,953,058.52	843,997,719.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	648,953,058.52	843,997,719.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	332,384,579.54	468,119,405.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	225,068,362.79	331,498,452.00
210101	Үндсэн цалин	166,676,246.77	239,452,624.13
210102	Нэмэгдэл	39,755,160.70	59,743,881.22

210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,075,999.31	5,803,599.65
210104	Урамшуулал	00.00	7,654,118.00
210105	Гэрээт ажлын хөлс	14,560,956.01	18,844,229.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,975,129.75	41,757,101.00
210201	Тэтгэврийн даатгал	23,626,729.75	28,849,082.77
210202	Тэтгэмжийн даатгал	2,087,100.00	3,379,062.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,669,500.00	2,437,760.36
210204	Ажилгүйдлийн даатгал	417,600.00	794,371.77
210205	Эрүүл мэндийн даатгал	4,174,200.00	6,296,823.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,109,600.00	34,526,145.00
210301	Гэрэл, цахилгаан	3,440,824.00	4,049,605.00
210302	Түлш, халаалт	1,692,830.00	2,235,334.00
210303	Цэвэр, бохир ус	1,381,799.00	2,551,606.00
210304	Байрны түрээс	15,594,147.00	25,689,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,743,487.00	11,132,947.00
210401	Бичиг хэрэг	1,990,000.00	7,452,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,012,600.00	1,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	419,937.00	893,547.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	320,950.00	1,687,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	143,000.00	22,894,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	19,844,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	143,000.00	00.00
210604	Урсгал засвар	00.00	3,050,800.00
2107	Томилолт, зочны зардал	115,200.00	00.00
210702	Дотоод албан томилолт	115,200.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,153,080.00	26,164,960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,093,600.00	25,575,470.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,480.00	59,480.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,076,720.00	145,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,911,720.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	165,000.00	145,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	316,568,478.98	375,878,314.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,743,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,743,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	305,200,535.98	359,911,396.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,451,077.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	305200535.98	355,460,319.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,367,943.00	14,223,318.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,367,943.00	12,308,700.00
213405	Хөрөнгийн		1,914,618.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	32,003,931.86	1,609,447.50
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	32,003,931.86	1,609,447.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	843,305.50
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	32,003,931.86	2,452,753.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	148,156,954.32	-84,640,639.46	63,516,314.86
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	148,156,954.32	-84,640,639.46	63,516,314.86
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	44,558,251.53	44,558,251.53
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	148,156,954.32	-7,374,093.30	140,782,861.02
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	148,156,954.32	-7,374,093.30	140,782,861.02
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	148,156,954.32	-7,374,093.30	140,782,861.02
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	30,933,541.67	30,933,541.67
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	148,156,954.32	23,559,448.37	171,716,402.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	428,678,700.00	424,227,623.00	4,451,077.00	98.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	428,678,700.00	424,227,623.00	4,451,077.00	98.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	427,935,100.00	423,484,023.00	4,451,077.00	98.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	313,176,600.00	312,654,223.00	522,377.00	99.8
210101	Үндсэн цалин	263,388,300.00	241,071,641.13	22,316,658.87	91.5
210102	Нэмэгдэл	42,924,300.00	58,124,864.22	15,200,564.22	135.
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,864,000.00	5,803,599.65	1,060,400.35	84.5
210104	Урамшуулал	00.00	7,654,118.00		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,080,700.00	39,415,948.00	664,752.00	98.3
210201	Тэтгэврийн даатгал	27,734,900.00	27,118,146.13	616,753.87	97.7
210202	Тэтгэмжийн даатгал	3,086,400.00	3,226,508.31	-140,108.31	104.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,469,200.00	2,315,717.09	153,482.91	93.78
210204	Ажилгүйдлийн даатгал	617,300.00	763,860.95	-146,560.95	123.7
210205	Эрүүл мэндийн даатгал	6,172,900.00	5,991,715.52	181,184.48	97.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,988,400.00	34,526,145.00	1,462,255.00	95.9
210301	Гэрэл, цахилгаан	4,463,200.00	4,049,605.00	413,595.00	90.7
210302	Түлш, халаалт	2,854,900.00	2,235,334.00	619,566.00	78.3
210303	Цэвэр, бохир ус	3,211,000.00	2,551,606.00	659,394.00	79.4
210304	Байрны түрээс	25,459,300.00	25,689,600.00	-230,300.00	100.9
2104	Хангамж, бараа материалын зардал	12,545,300.00	11,132,947.00	1,412,353.00	88.7
210401	Бичиг хэрэг	7,135,300.00	7,452,200.00	-316,900.00	104.4
210402	Тээвэр, шатахуун	2,154,400.00	1,100,000.00	1,054,400.00	51.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	743,000.00	893,547.00	-150,547.00	120.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	326,900.00	00.00	326,900.00	0.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,185,700.00	1,687,200.00	498,500.00	77.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,121,400.00	22,894,800.00	226,600.00	99.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	19,844,000.00	156,000.00	99.2
210604	Урсгал засвар	3,121,400.00	3,050,800.00	70,600.00	97.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,876,900.00	2,714,960.00	161,940.00	94.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,243,300.00	2,125,470.00	117,830.00	94.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00		100.0
210803	Даатгалын үйлчилгээ	100,800.00	98,010.00	2,790.00	97.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,800.00	59,480.00	41,320.00	59.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	145800.00	145000.00	800.00	99.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	145,800.00	145,000.00	800.00	99.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	743600.00	743600.00		100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	743,600.00	743,600.00		100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	743,600.00	743,600.00		100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	428,678,700.00	428,678,700.00		100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	428,678,700.00	428,678,700.00		100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	428,678,700.00	428,678,700.00		100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	843,305.50		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	2,452,753.00		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	25.00	1.00	96.1
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	17.00	1.00	94.44
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26.00	25.00	1.00	96.1
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	19.00	18.00	1.00	94.7
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	07.00	07.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	68,950,576.77	45,635,382.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	68,950,576.77	45,635,382.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,950,576.77	45,635,382.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,334,482.01	18,844,229.00
210105	Гэрээт ажлын хөлс	21,334,482.01	18,844,229.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,704,374.76	2,341,153.00
210201	Тэтгэврийн даатгал	2,704,374.76	2,341,153.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	23,450,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр		23,450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,911,720.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,911,720.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	70,166,500.00	47,550,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,166,500.00	47,550,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,200,000.00	47,550,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,966,500.00	00.00

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 19,844.0 мянган төгрөгийн зөрчил илэрч, алдааг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

Тайлант оны эцэст 19,844.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэхээр авлага үүсгэн ажилласан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант жилийн эцэст цалин хөлс, худалдан авалттай холбоотой авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллага бараа материалын зарлагыг зөвхөн шаардах хуудагт үндэслэн бүртгэсэн бөгөөд мөнгөн дүнгээр илэрхийлсэн НХМаягт БМ-3 зарлагын баримтыг хөтлөөгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", гэж заасантай нийцэхгүй, Сангийн сайдын 2017 оны "Маягт, заавар батлах тухай" 347 дугаар тушаалын дагуу бараа материалын зарлагыг НХМаягт БМ-3 маягтаар хөтлөөгүй, зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланд тусгагдах ажил гүйлгээ нь мөнгөөр илэрхийлэгдсэн байх бөгөөд НХМаягт БМ-3 зарлагын баримтыг хөтөлж баталгаажуулах, бараа материалын шаардахыг мөнгөн тэмдэгт, өртгөөр илэрхийлэгдсэн зарлагын баримтын хамт хөтлөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант оны эцэст 19,844.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэхээр зүй бус авлага үүсгэн ажилласан байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.	1	19,844.0					1	19,844.0				
Тус байгууллага бараа материалын зарлагыг зөвхөн шаардах хуудаст үндэслэн бүртгэсэн бөгөөд мөнгөн дүнгээр илэрхийлсэн НХМаягт БМ-3 зарлагын баримтыг хөтлөөгүй байгаа нь Сангийн сайдын 2017 оны "Маягт, заавар батлах тухай" 347 дугаар тушаалын дагуу бараа материалын зарлагыг НХМаягт БМ-3 маягтаар хөтлөх гэж заасантай нийцэхгүй, Төсвийн тухай хуулийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасныг мөрдөн ажиллаагүй байна. Энэ нь мөн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.	1						1					
Дүн	2	19,844.0					2	19,844.0				

ТАВ. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			